



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 1/05

Улаанбаатар хот

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг
хангах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Шилэн дансны тухай хуулийн 3, 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн төрөл, мэдээлэл байршуулах, хяналт тавих албан тушаалтны жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү жагсаалтын дагуу шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулж, хяналт тавих, улирал бүр тайлагнаж ажиллахыг газрын дарга нар, менежер, ерөнхий нягтлан бодогчид, шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах, хяналт тавих албан тушаалтныг томилон хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллахыг харьяа салбар нэгжийн дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны А/235 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН

1723 01 0068



Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн
А/Х.С. дугаар тушаалын хавсралт

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн төрөл, мэдээлэл байршуулах,
хяналт тавих албан тушаалтны ажилтны жагсаалт

Д/д	Мэдээллийн төрөл	Шилэн дансны тухай хуулийн заалт	Мэдээлэл оруулах төрөл МУЗГ-ын 29 дүгээр тогтоол	Мэдээлэл оруулах давтамж	Мэдээлэл оруулах хуулийн хугацаа	Мэдээлэл оруулах албан тушаалтан	Ерөнхий хяналт тавих албан тушаалтан
1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
Төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээлэл							
1	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилгот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт	6.1.1, 6.1.6, 6.3.1, 6.2.2, 6.2.3, 6.2.6, 6.3.3	Хавсралт 17	Бүтэн жилээр Хагас жилээр Улирал бүр Сар бүр	01 дүгээр сарын 10-ны дотор 8 дугаар сарын 15 Улирал бүрийн дараа сарын 08-ны дотор Дараа сарын 08-ны дотор	Хариуцсан эдийн засагч	Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын дарга
2	Дараа жилийн төсвийн төсөл	6.1.3	PDF файлаар	Бүтэн жил	9 дүгээр сарын 15		
3	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	6.4.1	PDF файлаар болон хавсралт 17	Нэмэлт өөрчлөлт орсон үед	7 хоногийн дотор		
4	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан	6.3.5	Хавсралт 6	Бүтэн жил Хагас жил	4 дүгээр сарын 25-ны дотор 8 дугаар сарын 15	Ахлах нягтлан бодогч	Ерөнхий нягтлан бодогч
5	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	6.4.5	Хавсралт 9	Тухай бүр	7 хоногийн дотор	Хариуцсан нягтлан бодогч	
6	Санхүүгийн тайлан	6.1.4	PDF файлаар	Бүтэн жил Хагас жил	4 дүгээр сарын 25-ны дотор		
7	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	6.1.5	PDF файлаар	Бүтэн жил	4 дүгээр сарын 25-ны дотор	Ахлах нягтлан бодогч	Ерөнхий нягтлан бодогч

1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын талаарх мэдээлэл							
8	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	6.1.1	Хавсралт 21	Бүтэн жил	01 дүгээр сарын 10-ны дотор		
9	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	6.2.4, 6.3.7	Хавсралт 3	Сар бүр	Дараа сарын 08-ны дотор		
10	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	6.3.6, 6.4.3, 6.8.2	Хавсралт 7	Тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор	7 хоногийн дотор	Хариуцсан нягтлан бодогч	Ерөнхий нягтлан бодогч
11	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	6.4.4	Хавсралт 8	Тухай бүр	7 хоногийн дотор		
12	Худалдан авах ажиллагааны тайлан	6.1.1	Хавсралт 22	Бүтэн жил	01 дүгээр сарын 15-ны дотор		
Бусад мэдээлэл							
13	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	6.1	PDF файлаар	Шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор	7 хоногийн дотор	Хуулийн мэргэжилтэн (гэрээний)	Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, менежер
14	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	6.4.8, 6.8.1	Хавсралт 10	Тухай бүр	7 хоногийн дотор	Хариуцсан нягтлан бодогч (тушаал), Хуулийн мэргэжилтэн (гэрээ)	Ерөнхий нягтлан бодогч, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, менежер

1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
15	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	6.1.5	PDF файлаар	Бүтэн жил	7 дугаар сарын 01-ний дотор	Ахлах нягтлан бодогч	Ерөнхий нягтлан бодогч
16	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	6.4.2	PDF файлаар	Тухай бүр	7 хоногийн дотор	Хариуцсан эдийн засагч	Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын дарга
17	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	6.4.7	Хавсралт 8	Сар бүр	Дараа сарын 08-ны дотор	Захиргааны мэргэжилтэн	Захиргаа, хүний нөөцийн газрын дарга
18	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	6.4.6	PDF файлаар	Хяналт шалгалтын дүн гарснаас хойш	7 хоногийн дотор	Хариуцсан нягтлан бодогч	Ерөнхий нягтлан бодогч

xxx xxx xxx